

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
2019.08.05-08.09

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. Тэр дундаа S&P 500 индексийн сагсанд багтаж буй эрчим хүчний салбарын компаниуд хамгийн их уналттай байв. АНУ-ын газрын тосны нөөц огцом нэмэгдсэнээр газрын тосны ханш буурсан нь ийнхүү нөлөөлжээ. Харин урт хугацааны мөнгөний бодлогын хүү сүүлийн гурван жилийн хамгийн доод төвшинд хүрч, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа эрхлэгч компаниудын хувьцаанд эерэгээр нөлөөлөв.

Даваа гарагт хөрөнгийн зах зээлийн индексүүд их хэмжээний уналттай хаагдсан ба үүний шалтгаан нь БНХАУ-н эрх баригчид юанийн ханшийг сулруулж, нэг ам. долларыг 7.0 юань хүрэхгүй болгон бууруулсан явдал юм. Шинжээчид АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаан даамжирч, улмаар валютын дайнд хүргэх боломжтой гэж үзэж байна. Хэдийгээр БНХАУ-ын эрх баригчид өрсөлдөөний зорилгоор валютын ханшид нөлөөлөхгүй гэсэн ч энэхүү ханшийн өөрчлөлт нь АНУ-н гаалийн татварын мэдэгдлийн хариу үйлдэл хэмээн мэдэгджээ.

БНХАУ-ын экспортын хэмжээ нэмэгдэж, нэг ам.доллар 7.05 юаньтай тэнцсэн нь хөрөнгийн зах зээлийн индексүүдийн уналтыг түр хугацаанд зогсоосон. Гэсэн ч АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп БНХАУ-тай хэлэлцээр хийх сонирхолгүй, мөн энэ оны 9-р сард тус улстай зохион байгуулагдах худалдааны асуудлын талаарх уулзалтуудыг цуцлах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн нь Баасан гарагт хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин унах гол шалтгаан болжээ.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд дэлхийн зах зээлийн чиг хандлагын даган уналттай хаагдлаа. Шинжээчид Европын зах зээлийн арилжааны хэмжээ бага байгаа нь хөрөнгө оруулагчид эрсдэлээс зайлсхийж буйг илтгэж байгаа гэж үзэж байна.

Лхагва гарагт гарсан мэдээний дагуу 6-р сард ХБНГУ-ын аж үйлдвэрлэлийн гарц 1.5%-аар буурсан нь шинжээчдийн таамаглаж байсан төвшнөөс өндөр байв. ХБНГУ-ын аж үйлдвэрлэлийн гарц буурсан, мөн даамжирч буй худалдааны маргааны асуудлаас үүдэн экспортод төвлөрсөн Герман улсын эдийн засаг хямралд орох магадлалтай байна. Ингэснээр сөрөг өгөөжтэй Германы Засгийн газрын бондын өгөөж улам буурав. Шинжээчид Их Британийн ДНБ 2-р улирлиралд үргэлжлэн өснө гэж таамаглаж байсан бол тус хугацаанд 0.2%-аар буурсан үзүүлэлттэй байлаа. Ийнхүү сүүлийн 7 жилийн хугацаанд тус улсын ДНБ анх удаа буурчээ.

Япон: Япон улсын бодит цалингийн хэмжээ 6 сар дараалан буурсан, мөн тус улсын Засгийн газар 10-р сард НӨАТ-ыг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн нь дотоодыг хэрэглээг цаашид бууруулах шалтгаан болж байгаа ажээ. Япон улсын дотоодын хэрэглээ нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 2.7% өссөн нь Япон улсын буурч буй экспортын сөрөг нөлөөг багасгаж байсан юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд огцом уналттай хаагдлаа. Ялангуяа технологийн компаниудын хувьцаа хамгийн их унасан үзүүлэлттэй байна. Энэхүү уналтын шалтгаан нь АНУ-ын эрх баригчид БНХАУ-ын харилцаа холбооны "Huawei Technologies" компанид технологи үргэлжлүүлэх нийлүүлэх хүсэлтэй АНУ-ын компаниудад лиценз олголтыг хойшлуулсан явдал юм.

БНХАУ болон АНУ-ын харилцаа доройтож байгаа нь АНУ БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд 25%-ийн гаалийн татвар ногдуулахад хүргэх магадлалтай гэж шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,395.33	-0.83% ▼
Dow Jones	АНУ	26,287.44	-0.75% ▼
S&P 500	АНУ	2,918.65	-0.46% ▼
Nasdaq	АНУ	7,959.14	-0.56% ▼
S&P/TSX	Канад	16,341.34	0.43% ▲
FTSE 100	Их Британи	7,253.85	-2.07% ▼
S&P/ASX 200	Австрали	6,584.40	-1.54% ▼
Nikkei 225	Япон	20,684.82	-1.91% ▼
Hang Seng	Хонг Конг	25,939.30	-3.64% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.44
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.14
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.32
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.30
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.13
DBM' 2023	USD	7.250%	104.65
TDBM' 2020	USD	9.375%	103.08

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.194	0.03 ▲
Libor 3M	2.176	0.06 ▲
Libor 6M	2.052	0.08 ▲
Libor 1YR	1.988	0.12 ▲
US 2YR Bond	1.647	-0.01 ▼
US 3YR Bond	1.591	0.00 ▼
US 5YR Bond	1.579	0.00 ▼
US 10YR Bond	1.745	0.02 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.08.09	Өөрчлөлт
USD	2,668.86	0.07% ▲
CNY	378.46	-1.56% ▼
EUR	2,986.19	0.79% ▲
RUB	40.85	-1.02% ▼
KRW	2.20	-0.90% ▼
JPY	25.19	1.00% ▲
CAD	2,018.27	0.04% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,496.95	3.89% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	16.98	4.78% ▲
Зэс	USD/lb.	258.90	0.68% ▲
Нүүрс	USD/MT	72.10	-3.74% ▼
WTI газрын тос	USD/bbl.	54.50	-2.08% ▼
Brent газрын тос	USD/bbl.	58.53	-5.43% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.12	0.00% -

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VI	8.10%
Бодлогын хүү	2019. VI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VI	11.13%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VI	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VI	10.68%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 47 компанийн 566.0 сая төгрөгийн 1,245,672 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Бөөний худалдаа” /BHL/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 345.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Стандарт агрикалчер групп” /SOH/ компанийн хувьцаа 23.08%-аар буурч 150.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 533 ширхэг үнэт цаас 53.7 сая төгрөгөөр арилжаалагджээ.


8-р сарын 09-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,561.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,395.33 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.83%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	619.8
Зах зээлийн үнэлгээ	2,561,595.8

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,395.33	-0.83% ▼
MSE I индекс	9,329.75	-1.01% ▼
MSE II индекс	8,059.26	-0.98% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	102,454	199,327,858
Говь	248,467	77,368,348
Монгол базальт	149,521	52,752,369
БиДиСек	56,801	47,428,900
АПУ	83,322	46,219,928

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Бөөний худалдаа	345.00	15.00% ▲
Хүрд	3,721.00	14.99% ▲
Монгол шилтгээн	340.00	14.29% ▲
Мерекс	25.50	13.03% ▲
БиДиСек	900.00	8.04% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Стандарт агрикалчер групп	150.00	-23.08% ▼
Хар тарвагатай	7,600.00	-14.85% ▼
Ноёт хайрхан	363.00	-14.59% ▼
Монгол шуудан	536.00	-12.85% ▼
Женко тур бюро	63.10	-9.99% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард секюритиз	243,636,943
БиДиСек	178,779,239
Бумбат-Алтай	128,569,049
Голомт Капитал	99,464,951
Гаули	90,398,448

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	549.59	584,864
Таван толгой	6,700.00	352,857
МИК Холдинг	13,900.00	287,860
Говь	300.00	234,034
Инвескор ББСБ	1,891.00	135,637

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	533	53,747,720	100,840	100,840	156	15.140%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” (TSX:ERD; MSE:ERDN) нь 2019 оны 8-р сарын 5-ны өдөр Монгол Улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газраас Баян Хөндий нөөцийг ашиглах MV-021444 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан тухай мэдэгдлээ.

Тус компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Петер Акерли: “Баян Хөндийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг авснаар өндөр агууламж бүхий ил орд болох Хөндий алтны нөөц олборлолтыг эхлүүлэх чухал ач холбогдолтой үйл явдал боллоо. Бид жилд 50 мянган унц алт олборлох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд цаашид нөөцөө нэмэгдүүлэх талаар анхааран ажиллах болно.” гэжээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Монгол базальт” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн биржийн 2-р ангилалд бүртгэлтэй “Монгол Базальт” ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа.

“Монгол Базальт” ХК нь үйлдвэрийн өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлж цагт 1 тонн эрдэс хөвөн үйлдвэрлэдэг байсныг 1.5 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлснээр 2019 оны хагас жилийн байдлаар борлуулалтын орлого 1.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 478.7 сая төгрөг буюу 74.9%-аар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн, энэ онд үйлдвэрлэлийн бүтээмжийг 2 дахин их буюу цагт 2 тонн эрдэс хөвөн үйлдвэрлэхээр үйлдвэрлэлийн шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд борлуулалтын орлогыг 4 тэрбум төгрөгт хүргэхээр ажиллаж байгаа тухай танилцууллаа.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“АПУ” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жилийн тайлангаа МХБ дээр олон нийтэд нээлттэй танилцуулах үйл ажиллагаанд АПУ ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг 2019 оны 8 дугаар сарын 7-ны өдөр оролцлоо.

Тайлант хугацаанд АПУ ХК болон түүний охин 9 компани нь нийт 2,031 ажилтантайгаар ажиллаж, нэгдсэн байдлаар дараах голлох үр дүнгүүдийг гаргасан байна. Үүнд:

-Бүтээгдэхүүний нэр төрөл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11% хувиар нэмэгдэж, 308 нэр төрлийн 62.9 сая литр бүтээгдэхүүн борлуулсан;

-Тайлант үеийн байдлаар улсын төсөвт төлсөн татварын хэмжээ нийт 140 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 17% хувиар өссөн;

-2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 46 төгрөг буюу нийт 48.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн нь өнгөрсөн 10 жилийн түүхэн хугацаанд хамгийн өндөр ногдол ашиг зарласан үзүүлэлт боллоо;

-Хүү, татвар, элэгдэл хорогдлын зардлаас өмнөх ашгийн хэмжээ буюу EBITDA өмнөх оны мөн үетэй ижил түвшинд буюу 56 тэрбум төгрөг гарсан үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Ард санхүүгийн нэгдэл” ХК нээлттэй хувьцаат компани болж, хувьцааны арилжаа эхэллээ

СЗХ-ны 2019 оны 5-р сарын 8-ны өдрийн 102 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Жинст-Увс” ХК (MSE:JIV)-д “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай хувьцаат компанийг нэгтгэхийг зөвшөөрсний дагуу тус нэгдсэн компани болох “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн үнэт цаас 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн AARD симболтойгоор арилжигдаж эхэллээ. Энэхүү үйл явдлыг тохиолдуулан СЗХ-ны дэд дарга Д.Баярсайхан, МХБ-ийн Захиргаа, Санхүүгийн газрын захирал Н.Дөл-Эрдэнэ, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн ТУЗ-ийн дарга П.Батбаяр, “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг болон бусад холбогдох албан тушаалтнууд арилжааны цан цохих ёслолын үйл ажиллагаанд оролцож, МХБ-ийн үнэт цаасны 6,031 дэхь удаагийн арилжааг эхлүүллээ.

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК нь “Жинст-Увс” ХК-тай ийнхүү нэгдсэнээр урвуу нэгдэл (reverse takeover) буюу хаалттай компани нээлттэй компанид нэгтгэгдэх үйл явц амжилттай хэрэгжиж, Монголын хөрөнгийн зах зээлд нэгэн шинэлэг үйл явдал боллоо.

Тус нэгдлийн бүрэлдэхүүнд “Ард Даатгал” ХК, “Ард Кредит ББСБ” ХК, “Ард Секюритиз УЦК” ХХК, “Ард Лайф” ХХК, “Ард Актив” ХХК, “Ард Менежмент” ХХК, “Ард Бит” ХХК, “Тэнгэр Систем” ХХК, “Монгол Шуудан” ХК, “ГөүПэй” ХХК, “Номын Хишиг” ХХК, “Крипто Үндэстэн” ХХК, “Дижитал Эксчэнж Монголиа” ХХК болон “ЭМИСи Партнерс” ХХК зэрэг компаниуд багтдаг бөгөөд өөрийн охин болон хараат компаниудаар дамжуулан Монголын хөрөнгийн зах зээлд идэвхтэй оролцдог билээ. Тухайлбал, тус нэгдэл нь 2016 онд “Монгол шуудан” ХК-ийн хувьчлалыг амжилттай хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож байсны зэрэгцээ “Ард даатгал” ХК болон “Ард кредит ББСБ” ХК нь МХБ-д үнэт цаасаа шинээр бүртгүүлж, олон нийтээс амжилттай хөрөнгө татан төвлөрүүлсэн билээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Говь” ХК хагас жилийн тайлангаа танилцууллаа

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Говь” ХК нь 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа Монголын хөрөнгийн бирж дээр 2019 оны 8 сарын 9-ний өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

-2019 оны эхний хагас жилд “Говь” ХК-ийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 хувиар өсч 68.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

-Хонконг болон АНУ-ын Сан Франциско хотод франчайз дэлгүүрээ нээж, гадаад зах зээлээ тэлэв.

-Хамгийн анхны 100% ноолууран нимгэн даавуун хослолыг худалдаанд гаргасан байна.

26 жилийн түүхтэй “Гоёо” ХХК-г худалдан авсантай холбогдуулан уг 2 компанийн нэгдэлтэй холбоотой ажил явагдаж байна.

“Говь” ХК нь цаашид энэ онд багтаан дэлхийн 2 дахь том зах зээл болох АНУ-д үйл ажиллагаагаа тэлж, Лос Анжелес хотод зөвхөн онлайнгаар борлуулалт хийх зорилготой өөрийн салбар компанийг нээхээр ажиллаж байгаагийн зэрэгцээ Тува, Чиндао, Киев хотуудад франчайз дэлгүүр нээж ажиллахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Оюу толгой” эхний хагас жилд 107 сая ам.долларын татвар төлжээ

“Оюу толгой” ХХК-ийн 2019 оны II улирлын санхүү гүйцэтгэлийн тайлан болон шинэчилсэн тойм мэдээллийг тус компанийн гүйцэтгэх захирал Армандо Торрес өнгөрөгч пүрэв гарагт олон нийтэд танилцууллаа.

Тус компани 2019 оны II улирлын 107 сая ам.долларын татвар төлжээ. Ингэснээр 2010 оноос хойш Монгол Улсад төлсөн нийт татвар, хураамж 2.4 тэрбум ам.долларт хүрч буй юм.

Тайлангийн хугацаанд тус компани 689 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласан бөгөөд дотоодын 484 компани нийт худалдан авалтын 76 хувийг хангажээ. 2010 оноос 2019 оны II улирал хүртэлх хугацаанд үндэсний худалдан авалтад 2.9 тэрбум ам.доллар, оны эхний хоёр улирлын байдлаар 222 сая ам.доллар, мөн хугацаанд Өмнөговь аймгийн нийлүүлэгчдээс авсан бараа, үйлчилгээ худалдан авалтад 488 сая ам.доллар зарцуулжээ.

Нийгмийн хариуцлагын хүрээнд ЦЕГ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, “Мобиком корпораци”-тай хамтран зам тээврийн ослыг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн “Яараад яахав дээ” аянд 280 сая төгрөгийн санхүүжилт хийжээ. Мөн Улаанбаатар хотоос Дорноговь аймгийн төв Сайншанд хүрэх замд хурд хэмжигч, иж бүрэн камер суурилуулахаар төлөвлөсөн байна.

2019 оны хоёрдугаар улирлын үйлдвэрлэлийн тайлангаас танилцуулбал:

-39.156 тонн зэс олборлосныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар бага,

-71.825 унци алт олборлосон нь 2018 оны II улиралтай харьцуулахад 43.7 хувиар илүү,

-Тээрэмдсэн хүдрийн хэмжээ өмнөх оныхоос 2.3 хувиар, өмнөх улирлиас 12.3 хувиар илүү байна.

Зургадугаар шатны хүдрийг түлхүү олборлож буйтай холбоотойгоор зэс, алтны агуулга он дуустал үргэлжлэн буурах төлөвтэй байгаа хэдий ч компани энэ оны зэс, алтны үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөө биелүүлэх боломжтой хэмээн үзэж байгаа аж.

Эх сурвалж: Montsame.mn



Экспорт 11 хувиар өсжээ

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт энэ оны эхний 7 сард 8,078.7 сая ам.долларт хүрчээ.

Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад гадаад худалдааны эргэлт 9.4 хувиар өссөн байна. Экспорт 4,571.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 400.8 сая ам.доллараар буюу 11 хувиар өсжээ. Харин импорт 3,507.2 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 241.5 сая ам.доллараар буюу 7.4 хувиар нэмэгдээд байна.

Гол нэрийн түүхий эдийн экспортыг авч үзвэл:

-Нүүрсний экспортын биет хэмжээ 20.8 сая тоннд хүрсэн нь үндсэндээ өнгөрсөн оны мөн үеийн хэмжээнд (2018 оны 7 сарын экспортоос 10.0 мян.тонноор бага) байна.

-Зэсийн баяжмалын экспорт 867.7 мянган тоннд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 19.0 мянган тонноор өсжээ.

Экспортын гол орлогын статистик мэдээг танилцуулбал:

-Нүүрсний экспортын орлого 1,879 сая ам.долларт хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 177.2 сая ам.доллараар өссөн,

-Зэсийн баяжмалын экспортын орлого 1,199.9 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 23.8 сая ам.доллараар нэмэгдсэн талаар Гаалийн ерөнхий газраас мэдээллээ.

Эх сурвалж: Montsame.mn

Монголбанк эхний 7 сард 7.5 тонн алт худалдан авлаа

Монголбанк 2019 оны эхний 7 сард 7.5 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 9.3 тонн үнэт металл худалдан авснаас 1.8 тонноор бага буюу 19%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 7 дугаар сард 1.5 тонн алт худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 134 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 106 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 2.2 тонн үнэт металл худалдан авч байснаас 649 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 7 дугаар сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 120,680.95 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.